



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/409

Хэрлэн сум

Мэдээ, мэдээлэлд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалтын ажлыг иргэдэд сурталчлах зорилгоор видео хийлгэхэд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 08-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж дүн	Нийт дүн
1	Залуучуудын соёл амралтын хүрээлэн	1	2,000,000	2,000,000
2	Жишиг гудамж	1	2,000,000	2,000,000
3	Залуучуудын спорт, хөгжлийн төв	1	2,000,000	2,000,000
4	Жишиг тоглоомын талбай	1	2,000,000	2,000,000
5	Авто зам	1	2,000,000	2,000,000
Нийт				10,000,000